



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/83

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2019” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Тайёо бридж интернэшнл ХХК-ийн “Тайёо” зочид буудлын 21/119, Цэлмүүн трейд ХХК -ийн “Дрийм” зочид буудлын 20/111, Ариг-Эрдэнэ ХХК-ийн “Холидей” зочид буудлын 20/457, Ариг-Эрдэнэ ХХК-ийн “Нова” зочид буудлын 20/458, Баттаурус ХХК-ийн “Вива апартмент” зочид буудлын 20/31, Мөнхжин трейд ХХК-ийн “М Хотел” зочид буудлын 20/438, Мини макс ХХК-ийн “Багануур-24” дэн буудлын 20/208, Текотек трейд ХХК-ийн “Угалз” дэн буудлын 20/465, Аглаг-Эрдэнэ ХХК-ийн “Аглаг-Эрдэнэ ” дэн буудлын 20/377, Алаг дөл ХХК-ийн “Мойлтын хүрхрээ” амралтын газрын 20/420, Лайт саунд ХХК-ийн “Гэрэл аялгуу” амралтын газрын 20/368 гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Х.Содномдэмбэрэл/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/-д үүрэг болгосугай.

7. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргал/-д даалгасугай.

ДАРГА



А.АРИУНГЭРЭЛ

1150500342

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 12 сарын
08-ны өдрийн А/83 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ 8936 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ


2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1.	Тайёо бридж интернэшнл ХХК	5264244	Тайёо	БГД-ийн, 20-р хороо, Москва гудамж 39-р байр
2.	Цэлмүүн трейд ХХК	2693135	Дрийм	ЧД-ийн, 4-р хороо, Бага тойруу Анкарагийн гудамж 19-2
3.	Ариг-Эрдэнэ ХХК	2543192	Холидей	БЗД-ийн 2-р хороо, Доржийн гудамж 20 тоот
4.	Ариг-Эрдэнэ ХХК	2543192	Нова	БГД-ийн 20-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 296/3 тоот
5.	Баттаурус ХХК	5719291	Вива апартмент хотел	ХУД-ийн, 4-р хороо, Вива сити хорооллын N-1
6.	Мөнхжин трейд ХХК	2543362	М хотел	БГД-ийн 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, АОС 8/7

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 12 сарын
08-ны өдрийн А/83 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ


2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1.	Ампер сторм ХХК	5418127	Скай	ЧД-ийн, 7-р хороо, Хувьсгалчдын Г10-9а
2.	Мини макс ХХК	2008912	Багануур 24	БД-ийн, 3-р хороо, Нугын тал хэсэг
3.	Текотек ХХК	5920167	Угалз	ЧД-ийн, 14-р хороо, Хайлаастын 24-5866
4.	Аглаг-Эрдэнэ ХХК	5175429	Аглаг-Эрдэнэ	ЧД-ийн 11-р хороо, Нуурын 19/404
5.	Жи Ар Ди реалти ХХК	6405452	Сити	БГД-ийн 17-р хороо, 4-р хороолол /16064/ Амарсанаагийн гудамжны 6/4

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал, жуулчлалын
газрын даргын 2021 оны 12 сарын
08-ны өдрийн А/83 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт



АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1.	Алаг дөл ХХК	5690773	Мойлтын хүрхрээ	НД-ын 1-р хороо, Мойлтын тохой
2.	Лайт саунд ХХК	5076803	Гэрэлт аялгуу	НД-ийн 6-р хороо, Хар ямаатын ам
3.	Тэрэлж бридж эрдэнэс ХХК	6714161	Тэрэлж бридж	НД-ын 1-р хороо, Хөх давааны энгэр гудамж 291, 1-5

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР